



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/121

Халбан

**Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалт, 8.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвийн гудамж, хороолол болон төвийн эргэн тойронд үүссэн хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсугай.

2.Нарийн Ухаагийн хогийн цэгийн эргэн тойронд үүссэн хог хаягдлыг гар аргаар цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасагт үүрэг болгосугай.

3.Албан байгууллага, аж ахуй нэгж, хувийн хэвшил, иргэдийн цэвэрлэх талбайн хуваарийг хавсралтаар баталсугай.

4.Нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбажав (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд: Д.Отгонжаргал (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Мөнх-Эрдэнэ (Халбан багийн Засаг дарга)

Б.Гүндсамбуу (Байгаль хамгаалагч)

Н.Цасанчихэр (Газрын даамал)

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

